

БАТЛАВ.Төсвийн байнгын
хорооны дарга



Ц.ДАВААСҮРЭН

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2014 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУГАЦААНД ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС ХИЙХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2014.04.15

№	Хийх ажил	Хугацаа
Нэг. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл дээр ажиллах		
1	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг чуулган, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах	V сард
2	“Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг чуулган, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах	VI сард
3	Шилэн дансны тухай хуулийн төслийг чуулган, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах	IV сард
4	Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулган, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах	IV-V сард
5	Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг чуулган, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах	V сард
6	Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг чуулган, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах	IV-V сард
7	Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулган, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах	V сард
8	“Шууд ардчилал, иргэдийн оролцоогоор дамжуулан төсвийн төвлөрлийг сааруулах үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулган, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах	IV-V сард
9	“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд санал, дүгнэлт боловсруулан Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэх	IV-V сард

**Хоёр.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлттэй
танилцах, мэдээлэл сонсох**

1	Үндэсний аудитын газрын 2013 оны үйл ажиллагааны тайланг Байнгын хорооны хуралдаанаар сонсох	IV сард
2	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны төсвийн гүйцэтгэлийн байдалд судалгаа хийж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллах	III, IV сард
3	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжүүлж байгаа зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэл, хэрэгжилтийн байдалд газар дээр нь очиж танилцах	IV сард
Гурав.Бусад ажлын талаар		
1	Улсын Их Хурлын 2014 оны хаврын чуулганы хугацаанд Төсвийн байнгын хорооноос хийсэн ажлын талаар хэвлэлийн бага хурал хийх	VII сар

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Боловсролын сайдын 2013 оны төсвийн гүйцэтгэлийн байдалд судалгаа хийж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч

С.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Б.Болор -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Цолмон -Улсын Их Хурлын гишүүн
Ж.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн
Л.Эрдэнэчимэг -Улсын Их Хурлын гишүүн


Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг:

Г.Даваажаргал -УИХ-ын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн зөвлөх
Б.Гандулам -Төсвийн байнгын хорооны Ажлын албаны зөвлөх
Г.Нарантуяа -Төсвийн байнгын хорооны Ажлын албаны референт
С.Уранчимэг -УИХ-ын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн референт
Д.Гэрэлт-Од -УИХ-ын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн референт
Д.Ням-Осор -УИХ-ын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн референт

2.Боловсролын сайдын 2013 оны төсвийн гүйцэтгэлийн байдалд судалгаа хийж санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд танилцуулахыг ажлын хэсэг /Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар/-т даалгасугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, А.Бакей, С.Батболд, Д.Батцогт, Ц.Даваасүрэн, С.Дэмбэрэл, С.Одонтуяа, Д.Оюунхорол, Г.Уянга нарын Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Даваасүрэн - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

С.Баярцогт - Улсын Их Хурлын гишүүн
С.Ганбаатар - Улсын Их Хурлын гишүүн
Ц.Цолмон - Улсын Их Хурлын гишүүн
Ж.Эрдэнэбат - Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг:

Ё.Мөнхбаатар - Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны Ажлын албаны ахлах зөвлөх
Г. Даваажаргал - Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн зөвлөх
Б.Энхбайгаль - Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал
Ё.Энхсайхан - Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны Ажлын албаны зөвлөх
Ц.Батбаатар - Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны Ажлын албаны референт
Г.Батхүрэл - Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт зохицуулалтын газрын орлогч дарга

Н.Нарангэрэл

-Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга

О.Хуягцогт

-Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга

Б.Сүх-Очир

-Сангийн яамны Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Ц.Мядагмаа

-Эдийн засгийн хөгжлийн яамны Нэгдсэн төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2.“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын хөтөлбөрт заасан үзүүлэлтүүдээс Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлын хэрэгжилтийг Засгийн газарт хариуцуулан гаргуулж, дүгнэлт хийж, Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох чиглэлээр энэ тогтоолын 1 дүгээр заалтад дурдсан Улсын Их Хурлын тогтоолд тусгах санал боловсруулж Байнгын хороонд танилцуулахыг ажлын хэсэг /Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн/-т даалгасугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ДАВААСҮРЭН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 01/05

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дах заалтыг үндэслэн Тогтоох нь:

1.Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Р.Бурмаа -Улсын Их Хурлын гишүүн



Гишүүд:

С.Баярцогт -Улсын Их Хурлын гишүүн
С.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн
С.Дэмбэрэл -Улсын Их Хурлын гишүүн
М.Зоригт -Улсын Их Хурлын гишүүн
Ж.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг

Ё.Мөнхбаатар -Төсвийн байнгын хорооны Ажлын албаны ахлах зөвлөх
Г.Даваажаргал -УИХ-ын Тамгын газрын хяналт үнэлгээний хэлтсийн зөвлөх
Ё.Энхсайхан -Төсвийн байнгын хорооны Ажлын албаны зөвлөх
М.Элбэгдорж -Төрийн байгуулалтын байнгын хорооны Ажлын албаны зөвлөх
Ц.Батбаатар -Төсвийн байнгын хорооны Ажлын албаны референт

2.Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэж, санал, дүгнэлт бэлтгэн Төрийн байгуулалтын болон Төсвийн байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэг /Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа/- т даалгасугай.





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:


С.Ганбаатар - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

С.Баярцогт - Улсын Их Хурлын гишүүн
Б.Болор - Улсын Их Хурлын гишүүн
Ч.Хүрэлбаатар - Улсын Их Хурлын гишүүн
Ж.Эрдэнэбат - Улсын Их Хурлын гишүүн

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төслийг бэлтгэн Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг /Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар/-т даалгасугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ДАВААСҮРЭН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шилэн дансны тухай хуулийн төслийг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:


Л.Эрдэнэчимэг -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Б.Болор -Улсын Их Хурлын гишүүн
С.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Цолмон -Улсын Их Хурлын гишүүн
Ч.Хүрэлбаатар -Улсын Их Хурлын гишүүн

2. Шилэн дансны тухай хуулийн төслийг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төслийг бэлтгэн Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг/-т даалгасугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ДАВААСҮРЭН